



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

02.05.12 № 01/374
танай -ны № -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ
СҮМҮН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ МӨНХӨӨНИЙ
БАТБАЯР ТАНАА

Хандивын тайлангийн дүгнэлт

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Мөнхөөний Батбаяр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Мөнхөөний Батбаяр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг бие даан нэр дэвшигч хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчид иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Бие даан нэр дэвшигчээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Мөнхөөний Батбаярт иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан эсэхийг дэмжих, нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Мөнхөөний Батбаяр нөхөн сонгуулийн өмнөх жилийн тайлант хугацаанд буюу 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР